

ТРАНСЦЕНДЕНТАЛЬ ГОО ЗҮЙ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛ

Б.Болд-Эрдэнэ*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор,
сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Иммануэл Кант, сэтгүүл зүй, танин мэдэхүй, мэдээлэл, хэрэгсэл, үр нөлөө, цэвэр оюун ухаан, шүүн шинжлэхүй

Мэдээллийн шинэ технологи, даяар сүлжээ түүний хэрэглээний хэт өсөлтийн өнөөгийн цаг үед мэдээллийн (сэтгүүл зүй буюу харилцаа) хүний оюун ухаанд үзүүлэх нөлөө (мэдрэмж төрүүлэх, анхаарал татах, сэтгэл татах) буюу туршлагын (мэдрэмж, төсөөлөл) хүрээ, идэвх өргөжин тэлэх нь гарцаагүй. Үүнийг ч Кант “Юмст танин мэдэхүй ямар янзаар, ямар ч байлаа гэсэн хэрэгслүүдийн тусламжтайгаар холбогдсон аливаа тохиолдолд тольдохуй бол (**хар ухаан. зох**) тэдгээрт шууд холбогддог танин мэдэхүйн арга маяг, хэрэгсэл болох түүнд аливаа сэтгэхүй тэмүүлдэг. Юм бидэнд хүртэгдсэн л бол тольдохуй байж л байдаг... Ингэхлээр мэдрэхүйн чанараар дамжин юмс бидэнд хүртэгддэг ба зөвхөн тэр л бидэнд тольдохуйг олгодог. Харин юмс оюун бодлоор дамжин сэтгэгддэг ба оюун бодлоос ойлголтууд үүсдэг билээ” хэмээн тодорхойлсноор тайлбарлаж болно (Кант.И, Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй (орчуулагч Ч.Даваадаш), 2024). (тал 78)

Үнэхээр сэтгүүл зүй, тэр дундаа дижитал даяар сүлжээний мэдээллийн орон зайн (юмс, үзэгдлийн) танин мэдэхүйн цар хүрээ, мэдрэмж төсөөллийн хүч, нөлөөг бүрэн тооцвол хүний оюун ухааны тольдохуйн (хар ухааны) холбогдол тэр чинээгээр өргөжих нь гарцаагүй. Цаашилбал тольдохуй нь цэвэр мэдрэмж гэхдээ ойлголттой нийцэж байж мэдлэг болох учир мэдээллийн (мэдрэмжийн) үнэ цэн, ач холбогдлыг (оюун бодол болох) сэтгэлгээний (мэдлэгийн) тэлэлтээр тодорхойлно. Харин энэхүү өөрчлөлтийг хөдөлгөгч хүч нь харилцаа юм. Учир нь оюун ухаан нь дангаараа бол (тархины хөгжил) үнэ цэнгүй зөвхөн хоол хүнс олох, аюулгүй байдлаа хадгалах, үр төлөө үлдээх, (яг амьтан шиг) зэрэг хязгаарлагдмал хүрээнд хэрэг болох төдий байх байсан ба харилцааны эрэлт шаардлага, нөлөөгөөр “өөртөө буй юмс” нь (Кант үүнийг танин мэдэж чадахгүй хэмээсэн) өөрчлөгдөж “өөрийн төлөө” болов. Тийнхүү харилцаа нь дэг журам, хэм хэмжээ, нийгэм гэсэн гурвал хүний хөгжлийн орчинг бүтээж, бусдын дунд байх (оюун ухааны дотоод болон гадаад тэнцвэржилт) нөхцөл шалтгаан (эрхшээх эсвэл эрхшээгдэх), үр дүн, (соёл, үнэлэмж, хүсэл) зэрэг оюун ухааны хөгжил, өөрчлөлтийг дагуул-

сан хэрэг. Өөрөөр хэлбэл бусадтай харилцахуй нь оюун ухааны танин мэдэхүйн эрэлт, зайлшгүй, үр дагавар болсон гэсэн үг юм.

Цэвэр оюун ухааны үүднээс харилцаа нь танин мэдэхүйн арга биш юм. Харилцаа нь ерөнхий түгээмэл чанараараа мэдээллийг түгээж, дамжуулж, авч буй үйл явц, харин мэдээлэл нь хувь хүний туршлага ч бус, ойлголт ч бус, бусдын бүтээсэн амьдрал, бодит байдлын тухай, хамгийн гол, чухал гэж үзсэн үзэгдэл, дүр, төсөөллийг хараангуйлан, сорчлон нэгтгэсэн төлөөлүүлэл юм. Энэ талаасаа мэдээлэл нь хүний оюун ухааныг тэтгэгч биш бүр “төөрөлдүүлэгч” гэж ч болно.

Гэхдээ харилцааг дан ганц мэдээллийн солилцоо хэмээн дүгнэж болохгүй бөгөөд хэрэгсэл, тэмдэгт, үр нөлөө түүнчлэн орчлон нөхцөл, цаг үе гээд олон хүчин зүйлтэй холбон үзэх ёстой. Мэдээллийн гол, чухал дүр, төсөөлөл гэдэг ч хүний санахуйн (мэдрэмж) эх сурвалж мөн тул тольдохуй (хар ухаан) ба априор мэдлэгийн “гүүр, холбогч” нь байж болох талтай. Цаашилбал сэтгүүл зүйн хувьд үнэ цэнтэй мэдээлэл бол үгүйсгэл (дедуктив) мэтгэлцээний (индуктив) гэсэн нийлэг, задлагын танин мэдэхүйн шалгуур эрэмбээр тодорхойлогдох боломжтой. Кант задлаг бодомжийг тайлбарлагч, нийлэгийг өргөжүүлэгч хэмээн тодотгожээ. Тэрээр цааш “...(задлаг) бодомжууд нь субъектийн ойлголтод өөрийн предикатаар юу ч нэмж оруулдаггүй харин зөвхөн түүний задлагаар хэсэглэх талаар түүнд захирагдсан ойлголтуудад хуваадаг, ...нийлэг бодомжууд нь субъектийн ойлголтод предикатыг нэмж оруулдаг” (тал 61) хэмээн тайлбарлажээ. Тиймээс шүүмжлэлт

нийтлэл нэвтрүүлэг нь нийлэг, өргөжүүлэгч бодомжид, асуудал дэвшүүлсэн нь задлаг, тайлбарлагч бодомжид тус тус тулгуурлах ёстой гэсэн үг. Бас задлаг нь мэдлэгийн (инфотаймент) харин нийлэг нь дата, сэтгүүл зүйн үндсэн зарчим юм.

Мэдээллээс илүүтэй харилцааны мөн чанарыг илэрхийллийн асуултын хариу нь хүртэхүйд (нөлөөлөхүй) оршдог. Үнэхээр мэдээллийг харах, сонсох, унших зэрэг хүртэхүйн ямар арга хэлбэрээр авч байгаа нь үр нөлөөг буюу танин мэдэхүйн бололцоог тодорхойлогч гол хүчин зүйл мөн. Тиймээс ч олон нийтийн харилцааны тэргүүлэх судлаач М.Маклюэн хэрэгсэл (өөрөөр хэлбэл хүртэхүй) бол мэдээллээс илүү утга агуулгыг тээгч гэсэн алдарт томъёоллоо дэвшүүлсэн хэрэг. Үүнийг ч Кантын “мэдрэхүйн чанараар дамжин юмс бидэнд хүртэгддэг ба зөвхөн тэр л бидэнд тольдохуйг олгодог. Харин юмс оюун бодлоор дамжин сэтгэгддэг ба оюун бодлоос ойлголтууд үүсдэг билээ. Гэхдээ аливаа сэтгэхүй эцсийн эцэст шууд эсхүл дам шинж тэмдгээр дамжин тольдохуйтай тэгэхээр бидний хувьд мэдрэхүйн чанартай холбогдох ёстой. Учир нь ондоо аргаар нэг ч юм бидэнд хүртэгдэж чадахгүй” хэмээн тайлбарласантай холбон дүгнэж болно. (тал 78).

Сэтгүүл зүй хөгжил өөрчлөлтийн түүх нь хэрэгслээс, мэдээллийн технологиос шууд хамааралтай байсан. Хэвлэх машин, радио хүлээн авагч, телевиз, компьютер гээд мэдээллийг түгээх, дамжуулах, хүртэх хэлбэр шинэчлэгдэхийн хэрээр, нөлөө, хэрэглээ цаашилбал нийгэм өөрчлөгдөж иржээ. Сонин хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, радио олон

нийтийн хүч түрэлтээр бүхнийг эрхшээх, телевиз хэт хэрэглээг эрхэмлэгч хүний сэтгэл зүйн ноёрхолд автах, компьютер “би” төвт амьдралын хэв маягийн нөлөөнд нэгтгэгдэх нийгмийн өөрчлөлтийн шалтгаан болсон. Гэхдээ мэдээллийн хэрэгслийн хүртэхүй нь бодит ахуй, амьдралынхаас тэс өөр, мэдээж үзэж, сонсох зэрэг мэдрэхүй, төсөөлөхүй, хүртэхүйгээр тольдохуйд хүрэх ч, тэр нь бодит ахуй, байдлын тодорхой хэсэг, үйл явдлыг сонгон онцлогдоогоороо оюун бодлын ойлголтод үндэслэгддэг хоёрдмол танин мэдэхүйн орчныг бүтээдэг.

Кант “Бид юмны нөлөөнд өртөгддөг учир төсөөллийн чадварт нөлөөлөх түүний үйлчлэл бол сэрэл юм. Юманд сэрлээр дамжин холбогддог тэр тольдохуйнуудыг эмпирик тольдохуйнууд гэж нэрлэдэг. Эмпирик тольдохуйн тодорхойгүй зүйлийг үзэгдэл гэж нэрлэдэг. Сэрлүүдэд тохирдог үзэгдэл дэх тэрийг би түүний матери гэж нэрлэдэг. Харин ачаар нь үзэгдэл дэх олон янзын зүйл нь тодорхой янзаар цэгцлэгдэж чаддаг тэрийг би үзэгдлийн хэлбэр гэж нэрлэдэг” гэж хүртэхүйн чанарыг тодорхойлжээ. (тал 78). Энэхүү танин мэдэхүйн тайлбарт шууд нийцэх мэдээллийн хэрэгсэл нь телевизийн нэвтрүүлэг, бүтээл юм. Телевизийн мэдээллийн давуу тал нь ч үйл хөдлөл, хэмнэл, өнгө, дүр дүрслэл, төдийгүй дуу чимээ, үг яриа, хөгжим зэргийн нэгтгэлт хүртэхүй билээ. Нөгөө талаар телевизийн нөлөөг догдлол мэдрэмжийг өдөөдөг (цочроодог), хамт нийтийн төсөөллөөр сэтгэгддэг, үйл явдал, баримтын “яаж” болсныг үзүүлдэг хэмээн тодотгодог. Тэгэхлээр дээрх телевизийн онцлогыг хүний сэрэл сэрэхүйтэй холбон тайл-

барлаж болно. Юуны өмнө телевиз нь эмпирик тольдохуй мөн боловч тодорхойгүй буюу үзэгдлийн түвшинд дагнан хүртэгддэг мэдрэхүйн хэрэгсэл аж. Өөрөөр хэлбэл сэрлүүдэд тохирдог матери биш мөртлөө тодорхой эмхлэгдсэн, оюун бодлын ойлголтод нийцэж байдгаараа үзэгдлийн хэлбэр болж байдаг өвөрмөц “юмс”-ын бодит орчин бол телевизийн нэвтрүүлэг гэсэн үг. Тэгэхлээр энд бас л хоёрдмол чанар буюу үзэгдэл ба материйн алиныг тольдохуйн холбогдол оршиж буйг түвэггүй ойлгож болно. Энгийнээр өгүүлбэл телевизээс хүн, бодит дүр дүрслэл, ахуйг үзэж байна гэдэг утгаараа сэрэлд тохирдог “матери”-ийг хүртэж буй ч хэсэгчилсэн, төлөөлүүлсэн, зохиомжилсон “матери”-ийг сонгон хүртэж байгаагаараа тодорхойгүй буюу үзэгдлийг хүртээж байдаг шалтгаан нь байна. Тэгэхлээр үзэгдлийн хэлбэр гэдэг талаасаа ч цэгцлэгдсэн мэт цэгцлэгдээгүй чанартай тул матери биш болж таарна. Цаашилбал априор мэдлэгийн хувьд ч хоёрдмол чанар телевизийн үзүүлж буй мэдээлэлд оршиж байгаа ажээ. Гэхдээ Кант матери, сэрлийг ангид тусдаа авч үзэхийг тодотгосон нь асуудлыг үргэлжүүлэн тодорхойлох боломжийг өгчээ. Үүнийг ч “нэгэнт сэрлүүд юугаар цорын ганц цэгцлэгдсэн ба тодорхой хэлбэртэй болгогдсон байж болдог тэр нь өөрөө өөрийн ээлжинд сэрэл байж болохгүй тул хэдийгээр бүх үзэгдлийн матери бидэнд зөвхөн априор өгөгдсөн байдаг ч хэлбэр нь тэдгээрийн хувьд бүхэлдээ сэтгэлд априор бэлнээр орших ёстой ба тийм учраас аливаа сэрлээс тусад нь түүнийг авч үзэж болно” (тал 79) гэж тайлбарлажээ.

Үнэхээр телевизийн “сэрэл” нь жинхэнэ утгаараа сэрэл биш юм. Тиймээс хүний танин мэдэхүйн жам ёсны зүй тогтлоос гаж, өөр үр нөлөөг (танин мэдэхүй) дагуулж, тэр чинээгээрээ Кантын дурдан буй тольдохуйн (хар ухаан) холбогдол, нийцлээс алсарч өнөөгийн хүний оюун ухааны зөрчлийг дагуулсан юм. Ийнхүү хатуу дүгнэхийн учир нь “телевиз төвт интернэтийн орчин” болсон сэтгүүл зүйн тэргүүлэх чиглэл нь баримтат, шинжлэх ухааны мэдээлэл болсноор ч юм уу эсвэл хүний түүх амьдралын хэв маягийн бодит жишээ нийгмийн сонирхлыг татаж байгаа дүр том ерөнхий “зургаар” бол хэт “битөвт” төсөөлөл, сэтгэгдлийн дарангуйллаас зугтах учир шалтгаанд байна. Кантын оюун ухааны шүүмжийн гол санаа ч “уран сэтгэмж бус харин туршлага, дүрслэн бодох бус харин мэдрэхүй гадаад юмсыг миний дотоод мэдрэмжтэй салшгүй холбодог.

Чухамдаа гадаад мэдрэхүй бол байгаагаараа миний гаднах ямар нэг бодит зүйлд холбогдох тольдохуйн холбогдол мөн бөгөөд гадаад мэдрэхүйн бодит дүрслэн бодохуйгаас ялгаатай нь тэрээр зөвхөн дотоод туршлагатай өөртэй нь энд болж байгаа түүний боломжийн нөхцөл болон салшгүй холбоотой байдагт л үндэслэгдэнэ” (тал 49) гэсэн хүний дотоод ертөнц хэзээ ч гадаад туршлагаас, гэхдээ энэ нь бодит ахуй, орон зай, цаг хугацааны зайлшгүй

нөхцөл, тольдохуйтай холбогдсон туршлагаас ангид байж чадахгүйд байгаа юм хэмээн тайлбарласанд оршино. Харин мэдээлэл нь бодит ахуй, цаг хугацааны эрхшээлээс ангид лаазалсан “юмс үзэгдэл ба эгшин” юм. Тиймээс ч бичиг үсгийг хүн төрөлхтний оюун, иргэншлийн хөгжлийн байгалийн бус хамгийн нөлөө үзүүлсэн хүчин зүйл, дэвшил гэдэг. Гэхдээ мэдээллийн юмс үзэгдэл нь “өөртөө буй” чанараа гээж шууд үзэгдлийн (танин мэдэхүйн эхний төрөл нь өөртөө буй юм, хоёр дахь нь энэ юмны

үзэгдэл байдаг гэж Кант тодорхойлсон) хэлбэрийнх байдаг. Мэдээлэлд сэрэл үгүй, “үхсэн”, “лаазлагдсан”. Гэвч их сэтгэгч минь “мэдрэхүйгээр хүртэгдэгч ертөнцөд бид хаа сайгүй, тэр байтугай юмсыг гүн гүнзгий судлахдаа ч хүртэл зөвхөн үзэгдлүүдтэй учирч байдаг. (тал 100) хэмээн дүгнэсэн нь асуудлыг тодотгосон хэрэг байв. Мэдээлэл нь

«

Мэдээлэл нь танин мэдэхүйн талаасаа зөвхөн үзэгдлээс эхэлж түүнээ мэдрүүлдэг гэдэг ч оюун санааны мөн чанарын хувьд зүй ёсны зүйл болов. Учир нь хүний оюун ухаан априор өгөгдөл тольдохуйн (хар ухаан) нөхцлийг ямар ч байдал, утгаар авч үзэхэд бүх юм зүйл өөрийн төлөө бус харин үзэгдэл, тэр нь бололцоотой юу гэдэгт л шүүн тунгааж байдаг гэсэн үг

»

танин мэдэхүйн талаасаа зөвхөн үзэгдлээс эхэлж түүнээ мэдрүүлдэг гэдэг ч оюун санааны мөн чанарын хувьд зүй ёсны зүйл болов. Учир нь хүний оюун ухаан априор өгөгдөл тольдохуйн (хар ухаан) нөхцлийг ямар ч байдал, утгаар авч үзэхэд бүх юм зүйл өөрийн төлөө бус харин үзэгдэл, тэр нь бололцоотой юу гэдэгт л шүүн тунгааж байдаг гэсэн үг. Цаашилбал Кант тольдохуйд буй бидний танин мэдэхүй нь “тольдохуй дахь байрлалаар холбогдлуудыг (цувралыг), байр-

лалын өөрчлөлтийн холбогдлыг (хөдөлгөөнийг) болон энэ өөрчлөлт нь өөрөөр нь тодорхойлдог хуулиудыг (хөдөлгөгч хүч) агуулна” (тал 103) гээд гадаад мэдрэмж, төсөөлөл нь хүний оюун ухааны эргэлзээгүй, зайлшгүй тольдохуй байдаг тухай тайлбарлан “сэтгэл хэрхэн өөрийгөө шууд бие даасан байдлаар төсөөлдөгөөр бус харин хэрхэн дотроосоо нөлөөлөлд өртөгддөгт нийцүүлэн, ингэхлээр тэрээр хэрхэн байгаагаараа бус харин хэрхэн өөртөө илэрдэгээр өөрийгөө тольддог байна (тал 104) гэж төгсгөжээ.

Тэгэхлээр мэдээллийн тэр дундаа харах тэмдэгтийн хэрэгслийн (телевиз, дижитал хэрэгсэл, зураг, график, фото зэрэг) нөлөөллийн хүч, хүрээ учир шалтгаан нь дотоод ухамсарлахуйн, тольдохуйн гадаад мэдрэмж төсөөллийн илэрхийлэлд нэгтгэгддэгт оршин байх нээ. Энгийнээр томъёолбол тольдохуй бол эргэлзээгүй, төсөөлөхүй бол зайлшгүй гэдэг утгаараа танин мэдэхүйн цорын ганц хөдөлгүүр бөгөөд зөвхөн энэхүү загвараар хүн ухаарч, төлөвшдөг ажээ. Тиймээс ч мэдээлэл нь бодит байдлаас илүү, үзэгдэл нь юмс, үйлээс илүү хүний дотоод ертөнцөд нөлөөлөх боломжтой сацуу өдгөө хүртэл хөгжин шинэчлэгдэж тэр чинээгээрээ нийгмийг өөрчилж иржээ. Ер нь хүн туйлын төгс, өөртөө буй юмсыг бус харин мэдэх, мэдрэх ёстой үзэгдлийг таньж ухаарах нь илүү үнэ цэнэтэй хэмээн мэдээллийн “орон зай, цаг хугацаа”-ны үүднээс дүгнэж болно. Сэтгүүл зүй ч баримтат, цаг үеийн чухал үйл явдал, үзэгдлийн тухай мэдээллийнх байж сая өөрийн онцлог, ялгахуй нь үнэлэгдэж ирсэн учиртай төдийгүй орчин үеийн хүний оюун ухааны нөлөө бүхий хүч болон

төлөвшсөн. Тольдохуйн (хар ухаан) талаасаа ч “холбогдол түүний байрлал, хөдөлгөөн хүч”-ний хуулийн мэдрэмжийг өдөөдөг төдийгүй танин мэдэхүйд үл хамаардаг сэтгэл ханамж, хүсэл зоригийг ч төрүүлдэгээрээ дүрст тэмдэгтийн мэдээллийн нөлөө гүн бөгөөд өргөн хүрээтэй юм.

Мэдээж өнөөгийн визуал, виртуал мэдээлэл, харилцааны орчинд бодит ахуй, юмс бус төсөөлөл, мэдрэмжийн үзэгдлийн эрхшээл хүний дотоод ертөнцийг эзэгнэж буйг нэмбэл нөлөө, үр дагаварын цар түвшин хүрээнд хүрснийг ойлгож болно. Гэхдээ Кант үзэгдэл хэмээх ойлголтыг өөртөө буй юм гэсэн ойлголтоос ялгах зорилгоор ашигласнаас биш тольдохуйн арга хэлбэрийн хувьд хүнээс өөрөөс нь бүх юм шалтгаална, бас танин мэдэхүйн уг сурвалж гэж тайлбарлажээ. Ийнхүү сэтгүүл зүйн нэр төр үүгээр аврагдлаа.

Үнэхээр сэтгүүл зүйн бүтээгдэхүүн бүр (мэдээ, сурвалжилга, контент) цаг хугацаа, орон зайн нөхцөлүүдээс ангид, устган хадгалсан “эгшин, үзэгдлийн лаазлал” байхыг эрмэлздэг учир юмсын объектив бус субъектив хэлбэрүүдийн түвшинд үнэлж, дүгнэх ёстой. Үүнийг ч Кант “...анх түрүүчийн биш байдаг учраас мэдрэмжийн гэж нэрлэдэг” (тал 106) гээд төсөөллийн чадвар объектын нөлөөллөөс шалтгаална хэмээн тайлбарлажээ.

Ингэхлээр мэдээлэл нь оюун ухааны шүүмжээр шинжилбэл хүний өөрийн дотоод ертөнц, мэдрэмж сэтгэл зүйн байдалд буй тэр дүр төсөөллөөр утга чанараа нээдэг болно. Цаашилбал үзэгдлийн “юм” байдгийн учир бодомж, мэдрэмжийн хязгаараас хальж гарахгүй боловч объектын хувьд хязгааргүй нөлөөлө-

хүйн хэлбэрийг агуулж болно. Гэтэл Кант зөвхөн боломжтой туршлагын объектын хувьд дээр дурдсан мэдрэмжийн хязгаар хүчинтэйг тодорхойлсон нь түүний эрин үед телевиз, компьютер үгүй байснаар тайлбарлаж байна.

Телевиз, дижитал мэдээллийн хэрэгсэл нь хүний танин мэдэхүйн юмсын объектын хүрээг эрс тэлж, орон зай, цаг хугацааны априор тольдохуйн боломжийн үндэслэлд “том асуултын тэмдэг” болов. Объектын хувьд өмнөх цаг үеийн хүний хэзээ ч хүртэж чадаагүй цар бололцоог нээсний хамт “юмсын” орон зай, цаг хугацааны шууд, зайлшгүй холбогдолд эргэлзээг дагуулжээ.

Ийн бөх зүрх гарган дүгнэсний учир нь нэгдүгээрт мэдээллийн дижитал, даяар орон зайд хүртэгдсэн бүхэн тольдохуйг нээдэггүй, төдийгүй юмсын нөлөөллийн тайлбарт мэдрэхүй чанар (соргог чанар) саармаг утгатай болсон, хоёрдугаарт орон зайг “бүтээж” үзэгдлийн салшгүй нэгэн хэсэг мэтээр төлөөлүүлж “эхлэл, төгсгөлтэй” болгосон, гуравдугаарт цаг хугацааны дараалалт чанар үгүйсгэгдсэн үзэгдэлд (юмс ч гэж хүлээн зөвшөөрөхөөр болсон) нийсэн уусаж түүгээр хэмжигдэхүүн, тольдохуй цэвэр хэлбэр, төгсгөлгүй чанарын тухай дүгнэлт бодит биш болсонд оршино.

Нөгөө талаар дээр өгүүлж буй дүгнэлтийг виртуал орчин дахь мэдрэхүйн чанар нь Кантынхаас өөр болж, төсөөлөл танин мэдэхүйн өдөөгч бус харин “Би” төвт илэрхийллийн хэрэгсэл (хүнийсэл) болсон өнөөгий хүний мөн чанартай холбож буйгаа, танин мэдэхүй нь сэтгэхүйд бус хэрэглээний сэтгэл ханамжид тэмүүлдэг болсон эдүгээчлэл, даяарчлалын

түрэлтийн үр дагавар хэмээн дүгнэж байгаагаа онцолж байна.

Орчин үеийн сэтгүүл зүй (мэдээлэл) нь үндэстэн дамнасан том компаний хэрэглэгчийг төлөвшүүлэх, зах зээлийг хамгаалах эрх ашигт бүрэн үйлчилж байгаа нь юмсын танин мэдэхүйн гоо зүйг мэдрэмжийн бус таашаалын түвшинд хүргэснийг олон жишээгээр тоочиж болно. Брэнд, тренд, даяарчлал, минимализм, хэт хэрэглээ, билэгдлийн эдийн засаг, виртуал нийгэм гээд хүний оюун ухааны бүтээл улам бүр өөрийн эх үндэс болсон гайхах, бишрэх, итгэх мэдрэмжээс хөндийрч “сэрэлд тохирохуйн шалгуур” нь матери үзэгдлийн ялгаа ангиллын асуудалд үнэ цэнэгүй шахуу байр суурьтай үнэлэгдэж байна.

Эцэст нь дүгнэхэд цэвэр төсөөлөл, тольдохуйн холбогдол мэдээлэлд ер үгүй бөгөөд тийм байх боломжгүй нь утга санаа, сэтгэл зүйн эх сурвалжаас илүүтэй даяар сүлжээнд байрших, анхаарлын төвд байх эрэлтэд үйлчлэх болсон нь ирэх цагийн гол сорилт болно.

Ашигласан бүтээл

1. Кант.И (2024) Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй (орчуулагч Ч. Даваадаш) Улаанбаатар

Summary

This paper explains the key concepts of cognition, effect, pure reason, judgment, as explained in the work of the great thinker Immanuel Kant "The Critique of Pure Reason", translated by Doctor of Philosophy, Professor Ch. Davaadash, on the concepts of journalism information, communication, and effect.

Keywords: Immanuel Kant, journalism, cognition, information, channel, effectiveness, pure reason, jurisprudence.